

ӨВЧТЭЙ ҮЕ – ТҮР ХУГАЦААГААР ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАРГҮЙ БОЛОХ

NEMOCENSKÁ буюу өвчтэй үед өвчний даатгалын тэтгэмжтэй байна. Энэ бол эрүүл мэндийн даатгал биш!

- Тэтгэмжийн зорилго нь эрүүл мэндийн шалтгаанаар ажилдаа явах боломжгүй, түр хугацаагаар хөдөлмөр эрхлэх боломжгүй ("хөдөлмөрийн чадваргүй, акт") иргэдэд (ажилтнуудад) үзүүлэх санхүүгийн баталгаа юм.



Хуулиараа өвчний даатгалын тэтгэмжийг ажил олгогч төлдөг. Хэрэв та хувиараа хөдөлмөр эрхэлдэг бол төлдөггүй (төлбөрийг сайн дурын үндсэн дээр төлдөг) бол энэ тэтгэмжийг авах эрхгүй.

Түр зуурын хөдөлмөрийн чадваргүйг таны эмчлүүлж буй эмч шийдвэрлэж, Хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдсан тухай шийдвэрийг ([eNeschopenky](#)), OSSZ - дүүргийн нийгэм хамгааллын хэлтэст илгээнэ. "Өвчтэй хүн" нь зөвхөн "түр хөдөлмөр эрхлэхгүй гэх даатгуулагчийн үнэмлэх" авна.

АНХААР! Хэрэв та өөрийгөө санаатайгаар хөдөлмөрийн чадвараа түр алдсан бол өвчний тэтгэмж авах эрхгүй болно! OSSZ нь тэтгэмжийг бүүрүүлэх эсвэл буцаан авах шийдвэр гаргадаг. Дараах нөхцөлүүдтэй орно: хэрэв согтуу, хар тамхи хэтрүүлэн хэрэглэсний улмаас зодоон болсон сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсний үүднээс болж санаатай гэмт хэрэг үйлдэлдэн эсвэл санаатайгаар гэмт хэрэг үйлдсэн бол.

Цалингийн нөхөн олговор:

- Ажилтан түр хөдөлмөрийн чадвараа алдсан эхний 14 хоногт ажил олгогчоос цалингийн нөхөн олговрыг дундаж орлогын 60% -ийн хэмжээгээр авна (өдөр тутмын бууруулсан үнэлгээний суурь гэж нэрлэгддэг).
- Хөдөлмөрийн чадвар түр алдсаны 15 дахь өдрөөс эхлэн ажилтан Чехийн Нийгмийн хамгааллын газраас цалингийн нөхөн олговор авдаг.
 - Хөдөлмөрийн чадвар түр алдсаны 30 дахь хоног хүртэл дундаж орлогын 60%, 31-60 дахь хоног хүртэл 66%, 61 дэх өдрөөс 72% байна.
 - Үйлдвэрлэлийн осол гарсан тохиолдолд дундаж орлогын 100% төлдөг.
 - Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны дээд хугацаа 380 хоног байна!
 - **АНХААР!** Хэрэв та ажиллаж байхдаа өндөр насны тэтгэвэр авч байгаа бол зөвхөн 84 хоногийн цалингийн нөхөн олговор (ажил олгогчоос 14 хоног, ЧНХГ-аас 70 хоног) авна гэдгийг анхаарна уу.
 - Төлбөр - цалингийн нөхөн төлбөрийг банкны данс руу эсвэл шуудангийн мэдэгдэх хуудсаар илгээдэг.

АНХААР! ӨВЧТЭЙ БАЙХ ҮЕН ТЭТГЭМЖ НЬ АМРАЛТ БИШ ЮМ. ТА ДЭЭР ШАЛГАЛТ ИРЭХ БОЛОМЖТОЙ!

"Өвчтэй хүн" бүр эмчлэгч эмчдээ байрлах хаягаа мэдэгдэнэ. Хэрэв эмч танд "гарах" (өдөрт хамгийн ихдээ 6 цаг) бичиг хийхийг зөвшөөрвөл энэ хугацаанд та хаяг дээр байх шаардлагагүй.

- Эхний хоёр долоо хоногт ажил олгогч шалгалт хийдэг.
- Хөдөлмөрийн чадвар түр алдсаны 15 дахь өдрөөс эхлэн ЧНХГ-ын эрх бүхий ажилтнууд шалгалтыг хийдэг (биеийн байцаалтаар өөрийгөө нотолсон, шалгалтын тэмдэглэл хийдэг).

Шалгалтыг ямар ч үед (амралтын өдрүүд эсвэл бүх нийтийн амралтын өдрүүдэд), мөн олон удаа байж болно. Хонхоо тэмдэглэсэн байхаас гадна хонх тань ажилч байхыг зөвлөж байна! Хэрэв танд хонх байхгүй бол энэ мэдээллийг ЧНХГ-т мэдэгдэх шаардлагатай бөгөөд шалгагч таны мэдээлсэн дугаарын утсаар холбогдоно.

Өвчтэй үеийн тэтгэмж дэлгэрэнгүй мэдээллийг эндээс авах боломжтой:

<https://www.cssz.cz/nemocenske>,

<https://www.mpsv.cz/socialni-zabezpeceni-cizincu-v-cr>



Spolufinancováno
Evropskou unií



MINISTERSTVO VNITRA
ČESKÉ REPUBLIKY



Poradna
pro integraci

Projekt "Centrum na podporu integrace cizinců v Ústeckém kraji" reg. č. CZ.12.01.02/00/23_008/0000008 je financován OP AMIF a MV ČR.